



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв”
ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/03-НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.open.audit.mn Архангай аймаг 2024 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор Б.Азантунгалаг Утас: 92091017 Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhengai@audit.gov.mn

2024.03.15 № 148

танай _____-ны № _____-т

“ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН ШИЛМЭЛ
СҮРГИЙН ҮРЖЛИЙН ТӨВ”
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Д.ТҮВШИНСАЙХАН ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэмандал сумын шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас “Эрдэнэмандал сумын шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчлүүд тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө нь дангаараа болон нийт дүнгээрээ материаллаг ба өргөн тархсан тул сөрөг дүгнэлт хүргүүлж байна. Үүнд:

1. Жилийн эцсийн санхүүгийн тайланд эргэлтийн сүргийн мал амьтан дансанд 468 толгой малыг 96,800,000 төгрөгөөр бүртгэсэн боловч тодруулга тайланд нас, зүс, ээмэгний дугаараар дэлгэрэнгүй бүртгэж баримтжуулаагүй, малын “А” данс, нярвын тайлангууд зөрүүтэй нь үлдэгдлийн дүнг нотлох хангалттай, зохистой нотолгоо болж чадахгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4¹.1, 13.1, 13.7, 14.4, 20.2 дахь хэсэг, УСНББОУС-12 дугаар стандартын 35, 44, 47 дугаар зүйлд нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
2. Арилжааны банкин дахь харилцах данснаас зарцуулсан 3,271,650 төгрөгийн зарлагын гүйлгээ нь цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй, анхан шатны баримтын шаардлагыг бүрэн хангахгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7 дахь хэсэгт заасантай нийцэхгүй, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
3. Хээлтүүлэгч мал түрээслүүлэх гэрээний дагуу нийт 8,880,000 төгрөгийн орлого төвлөрүүлэхээс тайлант онд 7,800,000 төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,080,000 төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд авлагаар бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4¹.1, 13.1, 13.7, дахь хэсэг, 14.4.2 дахь заалтад нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

4. Тайлант онд сумын ОНХС-аас 5,700,000 төгрөгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь Сангийн сайдын 20 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын заалтад нийцэхгүй, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
5. Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2023 оны орлого, эх үүсвэр болон ашиг алдагдлыг батлаагүй, нийт зардлыг 36,145,000 төгрөгөөр баталсныг гүйцэтгэлээр 53,731,295.52 төгрөгийн зардал гаргаж 15,161,295.52 төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

“Эрдэнэмандал сумын Шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ нь Хөвсгөлийн цагаан уул үүлдрийн хуцын генфондыг хамгаалж, тоо толгойг тогтвортой байлгах, орон нутагт сайжруулагчаар ашиглах, өсвөр хээлтүүлэгчийг бойжуулах зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2023 оны 07 сарын 03-ны өдрийн 07 дугаар тогтоолоор тус байгууллагын ТУЗ-ын дарга, гишүүдэд өөрчлөлт орсон байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1.00	ХӨРӨНГӨ		
1.10	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,796,160.50	628,574.98
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө мал амьтад	109,370,000.00	96,800,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	112,166,160.50	97,428,574.98
1.20	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
<u>1.30</u>	<u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u>	<u>112,166,160.50</u>	<u>97,428,574.98</u>
2.00	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.10	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	66,450.55	737,853.41
2.1.1.1	Дансны өглөг		-
2.1.1.2	Цалингийн өглөг		292,872.00
2.1.1.3	Татварын өр	66,450.55	154,581.41
2.1.1.4	ЭМНД -ийн шимтгэлийн өглөг		290,400.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	66,450.55	737,853.41
2.20	Өр төлбөрийн нийт дүн	66,450.55	737,853.41
	Эздийн өмч		
2.30	Өмч :		
2.3.1	а) төрийн		108,970,000.00
2.3.2	б) хувийн		
2.3.3	в) хувьцаат	108,970,000.00	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	3,129,709.95	(12,279,278.43)
2.3.10			-
2.3.11	Эздийн өмчийн дүн	112,099,709.95	96,690,721.57
<u>2.40</u>	<u>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</u>	<u>112,166,160.50</u>	<u>97,428,574.98</u>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	10,080,000.00	18,710,000.00
2	Борлуулалтын өртөг		30,325,188.38
3	Нийт ашиг (алдагдал)	10,080,000.00	(11,615,188.38)
7	Хандив тусламжийн орлого	13,600,000.00	5,700,000.00
8	Бусад орлого		14,160,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	21,769,585.91	23,653,800.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,910,414.09	(15,408,988.38)
19	Орлогын татварын зардал	19,104.14	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,891,309.95	(15,408,988.38)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,891,309.95	(15,408,988.38)
24	Орлогын нийт дүн	1,891,309.95	(15,408,988.38)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Халаасны хувьцаа	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	108,970,000.00	3,129,709.95	112,099,709.95
2	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	108,970,000.00	3,129,709.95	112,099,709.95
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(15,408,988.38)	(15,408,988.38)
4	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	108,970,000.00	(12,279,278.43)	96,690,721.57

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,080,000.00	24,410,000.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	10,080,000.00	18,710,000.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	13,600,000.00	5,700,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	22,122,239.50	26,577,585.52
1.2.1	Ажиллагчдад төлсөн	14,241,171.43	16,343,308.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,589,428.00	4,461,600.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,966,000.00	2,123,688.38
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,592,415.07	2,210,100.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	687,625.00	1,378,689.14
1.2.9	Бусад мөнгөн зарлага	45,600.00	60,200.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,557,760.50	(2,167,585.52)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,557,760.50	(2,167,585.52)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,238,400.00	2,796,160.50
6	<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u>	<u>2,796,160.50</u>	<u>628,574.98</u>

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

ДД	Зардлын зүйл анги	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин	19,800,000.00	18,981,673.00	818,327.00	95.87%
2	НДШ	2,330,300.00	2,020,413.00	309,887.00	86.70%
3	Бичиг хэрэг	150,000.00	138,600.00	11,400.00	92.40%
4	Тээвэр шатахуун	2,500,000.00	1,610,100.00	889,900.00	64.40%

Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	800,000.00	742,500.00	57,500.00	92.81%
6	Бараа үйлчилгээний бусад зардал	9,764,700.00	2,904,299.52	6,860,400.48	29.74%
7	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	800,000.00	180,000.00	620,000.00	22.50%
8	Бусад зардал	-	27,401,402.86.00	27,401,402.86.00	100 %
8	Зардлын нийт дүн	36,145,000.00	53,978,988.38	17,833,988.38	149.3 %

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа ¹ илрээгүй. Залруулагдаагүй 106,851.7 мянган төгрөгийн зөрчил ² илэрснээс 1,080 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 8,971.7 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 96,800 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 2 албан шаардлага, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой асуудалд 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ нь хээлтүүлэгч мал түрээслүүлэх гэрээний дагуу нийт 8,880.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс тайлант онд 7,800 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,080.0 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн, авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт, гэрээний 2 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрийн газрын төсөвт дутуу орлогыг төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ харилцах данснаас гарсан зарлагын гүйлгээ, цахим төлбөрийн баримтад бүртгэгдсэн анхан шатны баримтуудыг тулган шалгахад 3,271.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй, анхан шатны баримтыг бүрэн хангаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

5.2.2 Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ Тайлант онд 96,800.0 мянган төгрөгийн 468 толгой мал санхүүгийн тайланд тусгагдсан боловч малын дэлгэрэнгүй бүртгэлгүй, малын А данс, нярвын тайлан хоорондоо зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4."Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7.“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Малын нас, зүс ээмэгний дугаараар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, малчинтай тооцоо нийлж ажиллаагүй, байгууллагын анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, нягтлан бодох бүртгэлийг зохих хууль журмын дагуу хөтлөн ажиллаагүй тул төсөв захирагч Д.Түвшинсайхан, нягтлан бодогч Э.Наранжаргал нарт хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

5.2.3 Тайлант онд сумын ОНХС-аас 5,700.0 мянган төгрөгийн дэмжлэг авч зориулалтын дагуу зарцуулаагүй цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардалд зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 20 тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын заалтад нийцэхгүй, аудитын толилуулга болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Мөн ОНХС-ын журмыг зөрчин тусламж, дэмжлэг олгосон тул Эрдэнэмандал сумын засаг даргад албан шаардлага хүргүүлээ.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

5.2.4 Тус байгууллага нь дотоод хяналтын нэгжгүй, тайлант онд төлөөлөн удирдах зөвлөлөөс үйл ажиллагаанд нь хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3-т “Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-тай байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлөөлөн удирдах зөвлөлөөс байгууллагын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5.2.5 Тайлант онд 38,570 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн 53,731.3 мянган төгрөгийн зардал гаргаж 15,161.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн ИТХ-ын 4 дүгээр хуралдааны 6 дугаар тогтоолоор баталсан Шилмэл сүргийн үржлийн төвийн дүрмийн 5.2.3 “Үржлийн төвийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид үйл ажиллагааны зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг боловсруулан ашигт ажиллагааг нэмэгдүүлэх албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой.

Илрүүлэлт: Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.”Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, 20 дугаар зүйлийн 20.2.2.”Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах”, гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болох.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны дотор ирүүлэхийг анхаарна уу.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2024 оны 06 дугаар сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
											/мянган төгрөгөөр/	
Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй	1	1,080.0	1	1,080.0					-	-	-	-
Малын дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй	1	96,800.0							1	1		
Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	3,271.7			1	3,271.7						
ОНХС-ийн дэмжлэгийг зориулалт бус зарцуулсан	1	5,700.0			1	5,700.0						
Байгууллагын ашигт ажиллагааг нэмэгдүүлээгүй	1	-			1	-						
Дотоод хяналт хэрэгжүүлээгүй	1	-			1	-						
НББ бодлогын баримт бичиггүй	1						1	-				
Нийт дүн	7	106,851.7	1	1,080.0	4	8,971.7	1	-	1	1		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй	1	-			1	-		
Дүн	1				1	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1				1	-		

